



“МОНБИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 он 5 сар 26 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.2, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монбийф” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.33.3, “Таван Богд Трейд” ХХК-ийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01А-192 албан тоотыг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Монбийф” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн Пүрэв гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байр, 2-р давхарт байрлах хурлын танхимд болон цахим флатформ ашиглан цахимаар тус тус хосолсон хэлбэрээр хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

- 2.1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах;
- 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах;
- 2.3. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах;
- 2.4. Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
- 2.5. Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах;
- 2.6. “Монбийф” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх, батлах;
- 2.7. “Монбийф” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг танилцуулж, шинэчилж батлах;
- 2.8. “Монбийф” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой нэгж хувьцааны бодит үнэ цэнийг тогтоосон хөндлөнгийн үнэлгээний тайланг танилцуулах;
- 2.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тогтоосон тогтоолыг танилцуулах, батлах;

- 2.10. 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан 1 дугаартай Компанийн хэлбэр өөрчлөх тухай тогтоолыг хүчингүй болгох асуудлыг танилцуулах, батлах;
3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2023 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй Хуулийн зөвлөх Б.Бат-Эрдэнэ /Утас: 95958708/-тэй холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичиг, хурлаас гарах шийдвэрийн төсөл бэлэн болмогц дараах хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэд танилцуулсугай.
- 7.1. Компанийн оффис: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 25 дугаар хороо, Үйлдвэрийн төвийн бүс /16010/, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 96 тоот биечлэн;
- 7.2. Компанийн цахим хуудсаар- <https://www.monbeef.mn> хаягаар;
- 7.3. Хувьцаа эзэмшигчдийн харилцдаг үнэт цаасны компаниудаар.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны загварыг Хавсралт №3-аар, хурлын дэгийг хавсралт №4-өөр тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байхаар тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналын хуудсыг шуудангаар (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 25 дугаар хороо, Үйлдвэрийн төвийн бүс /16010/, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 96 тоот биечлэн) болон Batardene.b@tavanbogd.com цахим хаягаар тус тус хүлээн авах ба санал хүлээн авах сүүлийн өдөр нь 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 17:00 цаг хүртэл тогтоосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Эрдэнэбат овогтой Золбоог томилсугай.
12. Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр Ахлах нягтлан бодогч Ц.Батцэцэг, Маркетингийн ахлах менежер Г.Төвсанаа, Хуулийн зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Будмаа нарыг тус тус томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Номин, гишүүдээр Д.Хулан нарыг тус тус томилсугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрсүгэй
15. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг Хурлын дарга Э.Золбоо болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
16. Энэ тогтоолын хувийг хувьцаа эзэмшигч “Таван Богд Трейд” ХХК-д хүргүүлсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА Ж.БАРСБОЛД




Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	"Монбийф" ХК
Хаяг, утас	ХУД, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө, стадион оргил, Хаан цамхаг, 10-р давхар Утас: 95958708
Хурал хуралдах өдөр, цаг	2023 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Таван Богд Группийн төв байр, 2-р давхарт байрлах хурлын танхимд болон цахим флатформ ашиглан цахимаар тус тус хосолсон хэлбэрээр Утас: 95958708
Хурлын төрөл:	Ээлжит бус хурал
Хурал зарлагч	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2023 оны 05-р сарын 26-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2023 оны 05-р сарын 31-ний өдөр
Бүртгэх өдөр	2023 оны 06-р сарын 16-ны өдөр
Хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2023 оны 06-р сарын 05-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2023 оны 05-р сарын 29-ны өдөр
Хурлын даргын нэр	Э.Золбоо
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Тооллогын комиссын дарга Б.Номин, Тооллогын комиссын гишүүн Д.Хулан
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	1. ХЭ-ийн хурлын зарын загвар 2. "Монбийф" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан 3. "Монбийф" ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан 4. Компанийн 2023 оны төсвийн санал 5. ХЭ-ийн хурлын дэг, саналын хуудас 6. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл 7. Компанийн хэлбэр өөрчлөх төсөл болон бусад
Баримт, бичгийн хуудасны тоо хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА /Э.ЗОЛБОО/





**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР**

“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Мон Бийф” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн Пүрэв гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байр, 2-р давхарт байрлах хурлын танхимд болон цахим флатформ ашиглан зайнаас хуралдах тул та бүхнийг хуралд оролцохыг урьж байна. Хувьцаа эзэмшигч та хуралд цахимаар оролцох тохиолдолд 2023 оны 7 дугаар сарын 04-ний дотор дараах материалыг Baterdene.b@tavanbogd.com и-мэйл хаягаар илгээн цахим хуралд нэвтрэх эрх, кодоо авна уу.

Иргэн	Хуулийн этгээд
Иргэний үнэмлэхийн лавлагаа /e-mongolia ХУР системээс 2023.05.26-ны өдрөөс хойш авсан байх/	Хуулийн шаардлага хангасан итгэмжлэлийн хуулбар /Эрх бүхий этгээдээс, тухайн хуралд оролцож санал өгөх эрхийг олгосон байх/
Итгэмжлэлээр төлөөлж буй тохиолдолд хүчинтэй итгэмжлэлийн хуулбар	Итгэмжлэгдэгчийн иргэний үнэмлэхийн лавлагаа /e-mongolia ХУР системээс 2023.05.26-ны өдрөөс хойш авсан байх/
“Мон Бийф” ХК-ийн хувьцааг аль ҮЦКомпаниар дамжуулан хэдэн ширхэг хувьцааг эзэмшдэг болохоо нэвтрэх нэр код авах и-мэйлдээ бичих.	

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах;
3. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах;
4. Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
5. Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах;
6. “Монбийф” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх, батлах
7. “Монбийф” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг танилцуулж, шинэчилж батлах;
8. “Монбийф” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой нэгж хувьцааны бодит үнэ цэнийг тогтоосон хөндлөнгийн үнэлгээний тайланг танилцуулах;
9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тогтоосон тогтоолыг танилцуулах, батлах;

10. 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан 1 дугаартай Компанийн хэлбэр өөрчлөх тухай тогтоолыг хүчингүй болгох асуудлыг танилцуулах, батлах;

Хурлын материалтай танилцах:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигч та 2023 оны 06 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд дараах баримт бичигтэй компанийн албан ёсны (www.monbeef.mn) цахим хаягаар болон Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 25 дугаар хороо, Үйлдвэрийн төвийн бүс /16010/, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 96 тоот хаягт ирж, түүнчлэн Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас (www.mse.mn), Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан танилцах боломжтой.

Урьдчилан санал өгөх, асуулт тавих:

Хуралд биечлэн оролцох боломжгүй, урьдчилан санал өгөх, эсхүл асуулт тавих хүсэлтэй бол хувьцаа эзэмшигч та хурлын материалтай танилцан, саналыг хуудас болон асуултын маягтыг бөглөж өөрийн харилцагч брокер, дилерийн компаниараа дамжуулан өгөх, компани дээр биечлэн ирж өгөх эсвэл “Мон бийф” ХК-ийн хаягаар шуудангаар ирүүлэх, mb.legal@tavanbogd.com цахим хаягаар **2023 оны 06 дугаар сарын 29-ний 17:00 цагаас өмнө** тус тус ирүүлнэ үү.

Хурлын зохион байгуулалтын талаар тодруулах зүйл, санал хүсэлтээ хувьцаа эзэмшигч та бүхэн хурал зохион байгуулах комисстой дараах шугамаар ажлын өдрийн 08:30-17:30 цагуудад холбоо барина уу.

Утас: 95958708, 99022251 утсаар холбогдоно уу.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС.



"Мон Бийф" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 5 тоот тогтоолын Хавсралт №3.

"МОН БИЙФ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС-БИЧГЭЭР.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:.....

Регистрийн дугаар:.....

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:.....

Хурал хуралдах газар, өдөр, цаг: 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 10:00 цагт танхим болон цахимаар

Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.

Саналын хуудас бөглөх заавар: Ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг (✓) тэмдгээр тэмдэглэж санал болгоны ард гарын үсгээ зурна.

№	Хурлаар хэлэлцэн, батлах асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах			
2.	Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөөг батлах			
3.	"Монбийф" Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөхийг батлах			
4.	Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчилж батлах			
5.	Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тогтоосон тогтоолыг батлах			
6.	2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан 1 дугаартай Компанийн хэлбэр өөрчлөх тухай тогтоолыг хүчингүй болгохыг батлах			

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг

Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр

Гарын үсэг:.....

Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:

Регистрийн дугаар:

Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:.....

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд (доогуур зурах) тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: /...../

Гишүүн: /...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

.....

.....

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр

Регистрийн дугаар:.....

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:

.....

Албан тушаал:.....

Гарын үсэг:.....



"Мон Бийф" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 5 тоот тогтоолын Хавсралт №4.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

	Ажиллагаа	Хугацаа	Хариуцан танилцуулагч
1	Хурлын ирцийг бүртгэж, хурал даргалагчид мэдээлэх	09:00 – 09:55	Тооллогын комисс
2	Хурлын дарга хурал нээж хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулах, Тооллогын комиссын даргыг ирцийн талаар танилцуулахыг урих	10:00-10:05	Хурлын дарга
3	Тооллогын комиссын ирцийн талаар тогтоолыг танилцуулах	10:05-10:10	Тооллогын комиссын дарга
Танилцуулах мэдээллүүд:			
4	Хурлаар хэлэлцэх асуудал 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах; 2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах; 3. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах; 4. Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; 5. Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах; 6. "Монбийф" Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх, батлах 7. "Монбийф" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг танилцуулж, шинэчилж батлах; 8. "Монбийф" Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой нэгж	10:10-11:10	Компанийн менежментийн баг

	хувьцааны бодит үнэ цэнийг тогтоосон хөндлөнгийн үнэлгээний тайланг танилцуулах; 9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тогтоосон тогтоолыг танилцуулах, батлах; 10. 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан 1 дугаартай Компанийн хэлбэр өөрчлөх тухай тогтоолыг хүчингүй болгох асуудлыг танилцуулах, батлах;		
5	Хурлаар танилцуулагдсан мэдээлэл болон шийдвэрийн төсөлтэй холбоотой асуулт авах ажиллагааг эхлүүлэх	11:10-11:20	Хурлын дарга, хуралд оролцогчид
6	Танхимаас асуулт, харилт		Хурлын дарга, хуралд оролцогчид
7	Санал өгөх зааварчилгаа өгөх		Тооллогын комисс
8	Хурлаар танилцуулагдсан мэдээлэл болон шийдвэрийн төсөлтэй холбоотой ирүүлсэн асуултад хариулт өгөх	11:20-11:30	Менежментийн баг
9	Хэлэлцсэн асуудлаар санал хураалт танхимаар болон системээр дамжуулж санал хураах ажиллагаа /хурлыг түр завсарлуулах/	11:30-11:40	Тооллогын комисс /танхим болон систем/
Хурал завсарлах.			
10	Тооллогын комиссын дарга санал хураасан үр дүнг танилцуулах	11:40 – 11:45	Тооллогын комисс
11	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулаад хурлыг хаах	11:45– 11:55	Хурлын дарга болон ХЗБ комиссын гишүүд
12	Хурлыг хаах	11:45-12:00	Хурлын дарга

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС.